

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2022 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Төрийн албан хаагчийн тусгай шалгалтанд сул ажлын байрын 5 орон тоог зарлуулан шалгалтанд орсон иргэдээс 2 албан хаагч тэнцэн орон тоог нөхөн томилгоожуулж, зайлшгүй ажлын шаардлагаар 2 ажлын байранд хөдөлмөрийн гэрээгээр томилгоо хийж шинээр 3 иргэн ажлын байраар хангалаа. Эх үрсийн баяраар Алдарт Эхийн 1.2 дугаар одонг 25 эхэд хүндэтгэлтэйгээр гардуулсан. Ардын хувьсгалын 100-н жилийн ойн медалиар шагнуулахаар 90 иргэний материалыг журмын дагуу хүргүүллээ. Баяр наадмын комиссуудыг томилон бэлтгэл ажлыг хангаж байна.

Багийн хурлуудын товийг зарлан 8-н багийн ИНХ-ыг зохион байгуулж, ОНХС-ийн шинэчилэгдсэн журам, Хоршоо хөгжүүлэх сангийн журам, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, Татварын орлогын мэдээлэл, 2022 онд ОНХС-аар хийгдэх болон одоо гэрээ байгуулан хийгдэж байгаа ажлуудын явц байдлыг танилцуулж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажиллаа. Хөдөө аж ахуйн тооллого-2022 арга хэмжээг А/90 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 396 өрх түүврээр хамрагдаж, 6-н тоологч, 1 шалгагч, 6 жолооч, 8-н багийн Засаг дарга бүгд 21 ТАХ ажиллан тайланг аймагт хугацаанд нь хүргэлээ. Өнөөдрийн байдлаар 135235 толгой мал төл хүлээн авсан байна. мал төллөлт 73,8 хувьтай байна. Төлийн хорогдол 175 толгой төл мал байна.

Төрийн өмчийн тооллого зохион байгуулагдаж төсөвт 8 байгууллага орон нутгийн өмчит 1 газрын эд хөрөнгийг тоолж байна.

Өргөдөл гомдол 64 иргэнээс ирсэнээс 9 нь хугацаа болоогүй, 55-нь шийдвэрлэгдсэн. Өссөн дүнгээр 101 захирамж, .. тушаал гарсан.

Ардын Хувьсгалын 100, 101-н жилийн ой, Аймгийн 80-н жилийн ойг угтан “Сумын төвийн тохижилт өнгө үзэмж”-ийг сайжруулах зорилгоор Сумын Засаг даргын ААНБ-ын өнгө үзэмж, гаднах тохижилтыг сайжруулах тухай 2022 оны 01 тоот албан даалгаврыг гаргаж ААНБ-дад үүрэг чиглэл өгөөд байна.

Нийгмийн даатгал: шинээр 3 иргэнд өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр 4 иргэнд тогтоов. Нийгмийн даатгалын буцаан олголттой холбогдуулан сайн дурын даатгуулагч нарын гэрээг сунгах, ноогдуулалт хийх ажлыг хийж дуусгасан. Тэтгэврийг цаг хугацаанд нь тавьж, олгох хуудасаар 10 гаруй иргэний тэтгэврийг олгов. Сайн дурын даатгалд 3 иргэн, 0-3 насны хүүхдээ асарч байгаа 1 ээжийг сайн дурын даатгалд тус тус шинээр хамрууллаа.

ЕБС: Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөн болон бүх нийтийн мод тарих үндэсний өдрөөр байгууллагын өөрийн эзэмшлийн талбайд 2280 ширхэг улиас, хайлаас, шар хуйс, "Глаука" цэнхэр 6 ширхэг том гацуур, зулзган гацуур 10 ширхэгийг багш ажилчид болон ахлах ангийн сурагчдын хамт тарьсан.

Төгсөгчдөд гэрчилгээ гардуулах ёслол болж, нийт 130 суралцагч суралцагч гэрчилгээгээ гардан авсан.

Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол" төслийн ESeL хөтөлбөрт хамрагдаж, төсөл хэрэгжиж байгаа 5 аймаг 25 сумын дунд зохион байгуулсан сургуульд суурилсан энтрепрайз төслийн уралдаанд тус сургууль шалгарч 75 сая төгрөгийн санхүүжилт авахаар болсон.

ХАБЭА-н бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ЗДТГ-ын галын буланг тохижуулсан.

Хүний нөөцийн 1 удаагийн судалгааг Сүхбаатар аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн мэргэжилтэнд явуулсан.

Шинээр ажилд орсон 3, ажлын байр өөрчлөгдсөн 1 нийт 4 хүний анкетыг хүний нөөцийн програмд оруулсан.

ЭМТ нь МУЗГ-ын 224-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор баталгаат эх сурвалжийн мэдээ материал, гарын авлагыг ашиглаж ард иргэдэд үнэн бодит мэдээллийг түгээх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг цахимаар болон танхимаар сургалт, сурталчилгааны ажлыг тасралтгүй явуулан ажиллаж байна.

ГУА-47 дугаар анги нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Эрдэнэцагаан сумын худалдааны гудамжинд 500 ширхэг хайлас, ангийн байрлалд 219 ширхэг хайлас 3 ширхэг улиас модыг алба хаагчид суулгасан.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр нэгдсэн хөтөлбөр төлөвлөгөө гарган баярын хурал, шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн тоглолт, шагайн наадгай, дугуйн уралдаан, гар зургийн уралдаан, кино үзвэр зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт насанд хүрэгсэд 220 , хүүхэд 312 давхардсан тоогоор хамрагдсан байна.

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.